

ХУРАЛДААНЫ ТОЙМ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2017 ОНЫ АРВАНГУРАВДУГААР ХУРАЛДААН

Хуралдаан 2017 оны тавдугаар сарын 25-ны 11 цаг 15 минутад эхэлж, 11 цаг 48 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, 33 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Төрийн албаны зөвлөлийн Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай	<p>Монгол Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн "Гурав"-ын 3.3, "Цагдаагийн ерөнхий газрын бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэх тухай" Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/55 дугаар тушаал, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 1.2 дахь заалт, 2013 оны 105 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүний нийтлэг жишиг", Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн:</p> <p>1. Төрийн албаны зөвлөлийн Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн батлах Үүнд:</p> <p>Салбар зөвлөлийн дарга</p> <ul style="list-style-type: none">- Цагдаагийн ерөнхий газрын дарга <p>Гишүүд:</p> <ul style="list-style-type: none">- Төрийн албаны төв байгууллагын төлөөлөл- Цагдаагийн ерөнхий газрын Тэргүүн дэд дарга

		<ul style="list-style-type: none"> - Цагдаагийн ерөнхий газрын дэд дарга - Цагдаагийн ерөнхий газрын дэд дарга - Захиргааны удирдлагын газрын дарга - Хүний нөөц, сургалтын хэлтсийн дарга - Хуулийн хэлтсийн дарга <p>Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга</p> <ul style="list-style-type: none"> - Хүний нөөц, сургалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн <p>2. Төрийн албаны зөвлөлийн тус Газрын дэргэдэх Салбар зөвлөлийг удирдах ажилтны сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, дүгнэлт гаргаж нэр дэвшүүлэх, албан тушаалын зэрэг дэв олгох, албан хаагчийн гүйцэтгэлийн удирдлага, ёс зүй, төрийн албатай холбогдон гарсан гомдол, маргааныг хянан шийдвэрлэх чиг үүргийг хэрэгжүүлэх ажлыг мэргэшил арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Б.Баатарзоригт, Цагдаагийн байгууллагын төрийн тусгай албан тушаалд анх орох иргэний мэргэшлийн шалгалтыг зохион байгуулж, нэр дэвшүүлэх, анх орох иргэний болон төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албан хаагчийн нөөцийн сан бүрдүүлэх, албан хаагчийн сургалт хөгжил, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах чиг үүргийг хэрэгжүүлэх ажлыг мэргэшил арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг гишүүн С.Цэдэндамбад тус тус зөвлөх</p> <p>3. Төрийн албаны тухай хууль түүнтэй холбогдон гарсан дүрэм, журам, стандартыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, санаачилагатай ажиллахыг Төрийн</p>
--	--	---

		<p>албаны зөвлөлийн Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөл /Ө.Энхтөр/-д үүрэг болгох</p> <p>4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах, дарга, нарийн бичгийн дарга нарыг томилох тухай” Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 131 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын “Хоёр”-ын 3 дахь хэсэг, 2 дугаар хавсралтын “Хоёр”-ын 3 дахь хэсэг, “Төрийн албаны зөвлөлийн Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Зөвлөлийн 2014 оны 41 дүгээр тогтоол, “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн даргыг томилж, тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Зөвлөлийн 2015 оны 58, “Төрийн албаны зөвлөлийн Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлийн нарийн бичгийн даргыг томилж, тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Зөвлөлийн 2015 оны 140 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
2	Зарим албан хаагчдад зэрэг дэв олгох тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 20 дугаар зүйл, Улсын Их Хурлын 1995 оны 73 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох” журмын 2, 6 дахь заалт, “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журамд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын 2000 оны 20 дугаар тогтоолын 1-д заасны дагуу төрийн захиргааны албан тушаалын тэргүүн зэргийн тэргүүн түшмэлийн зэрэг дэв олгуулахаар ирүүлсэн саналыг хэлэлцээд, нэр бүхий албан хаагчид</p>

		тэргүүн зэргийн тэргүүн түшмэлийн зэрэг дэв олгуулах саналыг Засгийн газарт уламжлахаар шийдвэрлэв.
--	--	---

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
АЖЛЫН АЛБА**